

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА


БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРААС 2023 ОНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮР ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА



БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.12.01-ний өдрийн 6/24 дугаар "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай" тогтоолоор Баянхонгор аймгийн төсвийг 60,421.6 сая төгрөгөөр баталж, ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/24 дугаар "Аймгийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор 1,428.4 сая төгрөгөөр бууруулж 58,993.2 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар аймаг, сумдын ИТХ-аар 58,993.2 сая төгрөгийн нийт эх үүсвэрийг баталж, гүйцэтгэлээр 53,263.2 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн ажилласан байна.



Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татварын орлого	16,617.2 сая.төг	21,685.3 сая.төг	5,068.1 сая.төг
Татварын бус орлого	3,151.3 сая.төг	2,482.4 сая.төг	-668.9 сая.төг
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	10,140.4 сая.төг	10,113.3 сая.төг	-27.1 сая.төг
ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг	17,678.0 сая.төг	17,678.0 сая.төг	0 сая.төг
Бусад орлого	11,406.3 сая.төг	1,304.3 сая.төг	-10,102.0 сая.төг

Тайланд онд нийт орлогыг 20,144.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс татварын орлогыг 16,617.2 сая, татварын бус орлогыг 3,111.3 сая, хөрөнгийн орлогыг 40.0 сая, хандив тусламжийн орлогыг 40.0 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 25,903.6 сая төгрөг орж нийт орлогын төлөвлөгөө 5,769.6 сая төгрөгөөр давуулсан биелсэн байна.



-648.5	Хөрөнгийн татвар	
-194.3	Малын тоо толгойн албан татвар	
-148.0	ААНОАТ	
-79.0	Газрын төлбөр	
-64.7	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	
-29.3	Хөрөнгө борлуулсны орлогын татвар	
-11.9	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	
-7.1	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	
-4.0	Бууны албан татвар	
0.5	Ойн нөөц ашигласны төлбөр	
14.9	АТБӨЯХ-ийн албан татвар	
29.3	Үйл ажиллагааны орлогын албан татвар	
29.6	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	
77.1	Бусад татвар	
110.5	Улсын тэмдэгтийн хураамж	
115.2	Дуудлага худалдааны орлого	
2,009.4	ЦХТАО-ын албан татвар	
3,634.8	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	

Тайланд онд төлөвлөсөн татварын орлогыг биелүүлж ажилласан ч аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, малын тоо толгойн албан татвар, газрын төлбөр зэрэг зарим татварын орлогын төлөвлөгөө биелээгүй нь байна.



НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ


НИЙТ ЗАРДАЛ



Хөрөнгийн зардлын гүйцэтгэл



Зээлийн төлбөрийн гүйцэтгэл



ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ



Монгол УИХ-аас төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, ханалт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталж мөрдүүлсэн байна.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

“Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоол

- 1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх;
2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх;
3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах;
4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.

Баянхонгор аймгийн 2022 оны төсвийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 9/24 дүгээр тогтоолоор 2,406.2 сая төгрөгөөр бууруулж 35,221.5 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Дээрх төсвийн тодотголтой холбоотой зарим онцлог арга хэмжээг сумын төвшинд хэрэгжүүлэх, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор сумдын 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжийг сумдад хүргүүлсэн.



ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Баянхонгор аймгийн сумдын ИТХ-аас

Сумдын төсөвт тодотгол хийж төсвийн нийт зардлыг 2,080.0 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.



ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАС

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн


Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна. *Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг*

Баянхонгор сум: Засаг даргын 2022 онд төсвийн зардлын хэмжээг 1,157.0 сая төгрөгөөр нийт зардлыг бууруулан баталж, аймгийн төсвөөр олгох санхүүгийн дэмжлэг 328.8 сая төгрөгийг хасаж гүйцэтгэлээр 713.6 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн

Баян-Овоо сум: Засаг даргын 2022 оны төсвийн зардлыг 293.4 сая төгрөгөөр бууруулж аймгийн төсөвт 241.4 сая төгрөг төвлөрүүлсэн.



НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗӨРЧИЛ




Нийт алдаа зөрчлийн ангилал

Төрийн байгууллагаас 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн 27% буюу 2,644.4 сая төгрөгийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал тус зөрчлийн 260.9 сая төгрөгийн зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн зөрчил байна.



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчил /сая.төг/

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 260.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 16.9 сая төгрөгийн зөрчилд 25 төлбөрийн акт тогтоож, 98.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 20 албан шаардлага өгч, 145.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 26 зөвлөмж хүргүүлсэн




Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор 195.8 сая төгрөгийн 125 зөрчил илэрснээс 46 албан шаардлага, 195.8 сая төгрөгийн 79 зөвлөмж хүргүүлэн ажилласан.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮН



Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.4, 8.9.8-д заасан аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 123 байгууллага (49 төсвийн байгууллага, 8 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төв, 42 тусгай сан, 20 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч), төсвийн ерөнхийлөн захирагч 1, улсын төсвийн 30, боловсролын салбарын 70, эрүүл мэндийн байгууллагын 23, соёлын байгууллын 22 нийт 269 байгууллагын санхүүгийн тайлан болон ангилагдаагүй зардал, замын сан, техник хяналт, барьцаа хөрөнгийн данс, нийт 4 дансны гүйлгээ нэгтгэгдсэнээс 269 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулсан.



Аудитын санал дүгнэлт



ӨӨРЧЛӨЛТГҮЙ 120

ТЕЗ-1, ТТЗ-14, ТШЗ-97, Тусгай сан-1
Нийт 120 байгууллагын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" буюу зөрчилгүй санал дүгнэлт өгсөн.



ХЯЗГААРЛАЛТТАЙ 17

ТТЗ-6, ТШЗ-11, Нийт 17 байгууллагын санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" буюу өөрчлөлттэй санал дүгнэлт өгсөн.

БАЯНХОНГОР АЙМГИЙН САНХҮҮГИЙН НЭГТЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 154,795.3 сая төгрөг болж өмнөх оноос 46.8 хувиар буурсан нь төсвийн шинэчлэлтэй холбоотойгоор нийт 154,316.5 сая төгрөгийн хөрөнгийг харьяа ТЭЗ-чдын санхүүгийн тайланд шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой байна.

— МӨНГӨН ХӨРӨНГӨ —




— АВЛАГА —




— НИЙТ ӨР ТӨЛБӨР —



— БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР —



— УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР —




ОНӨААН-ҮҮДИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ




АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ



Аудитаар нийт 9,721.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 2,470.5 сая төгрөгийн 101 алдааг санхүүгийн тайланд залруулж, 720.4 сая төгрөгийн 183 төлбөрийн акт тогтоож, 2,362.5 сая төгрөгийн зөрчилд 179 албан шаардлага хүргүүлж, албан тушаалтанд хариуцлага тооцох 295.7 сая төгрөгийн 12 санал, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 3,872.4 сая төгрөгийн 370 зөвлөмжийг хүргүүлсэн



- 124 байгууллага**
Орон нутгийн байгууллага: Нийт 124 байгууллага аудитад хамрагдаж 6,377.5 сая төгрөгийн зөрчил алдаа, зөрчил илэрсэн
- 70 байгууллага**
Боловсролын салбар: Нийт 70 байгууллага аудитад хамрагдаж 1,133.5 сая төгрөгийн зөрчил алдаа, зөрчил илэрсэн
- 24 байгууллага**
Соёлын салбар: Нийт 24 байгууллага аудитад хамрагдаж 210.3 сая төгрөгийн зөрчил алдаа, зөрчил илэрсэн
- 23 байгууллага**
Эрүүл мэндийн салбар: Нийт 23 байгууллага аудитад хамрагдаж 1,176.4 сая төгрөгийн зөрчил алдаа, зөрчил илэрсэн
- 28 байгууллага**
Бусад: Нийт 28 байгууллага аудитад хамрагдаж 823.8 сая төгрөгийн зөрчил алдаа, зөрчил илэрсэн



Орон нутгийн байгууллага:

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 124 байгууллага аудитад хамрагдаж 6,377.5 сая төгрөгийн зөрчил алдаа, зөрчил илэрсэн нь нийт алдаа зөрчлийн 66%-ийг эзэлж байна.

Аймгийн ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн шийдвэрлэлт /тоогоор/



Аймгийн ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн ангилал /төсвийн захирагчаар сая.төг/



Бусад ТЭЗ-ийн харьяа байгууллага:

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 28 байгууллага аудитад хамрагдаж 823.8 сая төгрөгийн зөрчил алдаа, зөрчил илэрсэн нь нийт алдаа зөрчлийн 8%-ийг эзэлж байна.

Бусад ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн шийдвэрлэлт /тоогоор/



Эрүүл мэндийн салбар:

Нийт 23 байгууллага аудитад хамрагдаж 1,176.4 сая төгрөгийн зөрчил алдаа, зөрчил илэрсэн нь нийт алдаа зөрчлийн 12%-ийг эзэлж байна.

Эрүүл мэндийн салбарын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн шийдвэрлэлт /тоогоор/



Боловсролын салбар:

Нийт 70 байгууллага аудитад хамрагдаж 1,133.5 сая төгрөгийн зөрчил алдаа, зөрчил илэрсэн нь нийт алдаа зөрчлийн 12%-ийг эзэлж байна.

Боловсролын салбарын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн шийдвэрлэлт /тоогоор/



Соёлын салбар:

Нийт 70 байгууллага аудитад хамрагдаж 210.3 сая төгрөгийн зөрчил алдаа, зөрчил илэрсэн нь нийт алдаа зөрчлийн 2%-ийг эзэлж байна.

Соёлын салбарын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн шийдвэрлэлт /тоогоор/

